



Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны хийсэн ажлын бичмэл тайлан

ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ХҮНИЙ НӨӨЦ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Тус хэлтэс нь 2022 онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/22 дугаар тушаалаар 4 тасаг 47 орон тоотой батлагдсан бүтэц зохион байгуулалтаар ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар орон тооны гүйцэтгэл 40 байна.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээний чанартай, хүртээмжтэй, шуурхай, нээлттэй, ил тод байдлыг хангах зорилт тавин ажиллаа.

Төрийн албаны шалгалтад тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн иргэн байхгүйн улмаас өндөр насны тэтгэвэр, жирэмсэн, амаржсан, хүүхдээ асрах чөлөө авсан ажилтны сул орон тоог (ялангуяа сумдад) нөхөхөд хүндрэл үүсэж, төрийн албаны тасралтгүй, шуурхай байдлыг алдагдуулж байна. Тайлант хугацаанд Өлзийт, Норовлин, Баян-овоо, Гурванбаян сумын нийгмийн даатгалын байцаагч, Сургалт сурталчилгаа сүлжээ хариуцсан мэргэжилтэн, Бор-Өндөр сумын НДТасгийн байцаагч, нийгмийн хамгааллын улсын байцаагч гэсэн албан тушаалын сул орон тоо гарч зохих хууль, тогтоомжийн дагуу аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн боловч нөөцөд шаардлага хангасан ажилтан байхгүй байна.

№	Албан тушаалын ангилал	төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Удирдах албан тушаалтан	1	1
2	Гүйцэтгэх албан тушаалтан	41	34
3	Үйлчилгээний	5	5
Нийт		47	40

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 2023 онд 1288.8 сая төгрөг батлагдсан. Батлагдсан төсвийн 761,9 сая төгрөгийг цалин хөлсөнд, нийгмийн даатгалын шимтгэлд 97,2 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 40,9 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 20.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 3,5 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 36.3 сая төгрөг, томилолтын зардалд 5.8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,9 сая төгрөг, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд 5,7 сая төгрөг, мэдээлэл сурталчилгаанд 3,0 сая төгрөг, өмгөөлөл хуулийн зөвлөх үйлчилгээний зардалд 0,4 сая төгрөг, ЭХМК-н зардалд 37,4 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулалд 4,6 сая төгрөгийг тус тус эдийн засгийн ангилал зориулалтаар батлагдсан төсвийн хүрээнд зарцуулан ажиллаа.

- Хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул Аймгийн Аудитын газраас **ЗӨРЧИЛГҮЙ** дүгнэлт авсан.
- Нийгмийн даатгалын байгууллагын эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө эзэмшүүлэх судалгааг маягтын дагуу гарган хүргүүлж 2022 оны **“Төрийн өмч эзэтшүүлэх”** гэрээг **94** хувьтай дүгнүүлсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хэлтсийн даргын А/01 тоот тушаалаар батлагдсан хэлтэс болон сумдын 2022 оны архивийн баримт тушаах хувиарийн дагуу хүлээн авч хяналт шалгалтын байцаагчаар баталгаажуулан архивийн нэгж үүсгэлээ. 2022 оны архивын 159 ширхэг баримт бичгийг хэлтэс болон сумдын байцаагч, ажилтнуудаас хуулийн хугацаанд хүлээн авч, түр хадгалах, байнга хадгалах гэсэн төрлөөр ангилан, хадгаламжийн нэгж бүрдүүлэн байгууллагын архивыг цэгцлэн ажилласан. Мөн 784 нас барсан болон зогсоогдсон тэтгэврийн хувийн хэргийг сумдаас хүлээн авч архивийн нэгж болгон хадгалсан. “Нийгмийн даатгал” гар утасны аппликейшн, E-Mongolia системийг иргэдэд сурталчилан мөн үйлчилгээний чанарыг сайжруулж цар тахалын үед даатгуулагчдыг өөрийн биеэр ирүүлэхгүйгээр нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг олгох, хэлтсүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг хэвшил болгон ажиллаж байна. Хэлтсийн архиваас тайлант жилийн хугацаанд 658 хүний нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг олгосон. Үүнээс биечлэн 298, QR кодтой 72, хэлтэс хооронд Able програм ашиглан цахимаар дүүрэг, хэлтэс, сумдын байцаагч хооронд 288 иргэний хүсэлт хүлээн авч даатгуулагчийн хүсэлтийг шийдвэрлэсэн бөгөөд Архив, албан хэрэг хөтлөлт шийдвэрлэлтийн мэдээг улирлаар болон хагас, бүтэн жилээр гаргаж НДЕГ-т хүргүүлэн ажилласан.

Хэлтсийн дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх

Монголын цахилгаан холбоотой 05 дугаар сараас эхлэн хамтран ажиллах гэрээ байгуулан Нийгмийн даатгалын 70562212 дугаарыг “Call center” үйлчилгээнд холбон шаардлагатай байцаагч, албан хаагчийн албан тушаал, дугаарыг оруулан өгснөөр иргэд даатгуулагч хэрэгтэй мэдээлэл, зөвлөгөөг энгийн утасны тарифаар авах боломжтой болсон.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО

2023 оны сангийн орлогын төлөвлөгөө **47530.0** сая төгрөгөөр батлагдсанаас нийгмийн даатгалын сангийн орлого **49524.6** сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөг **104.2** хувиар биелүүлсэн.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 1-11 сард 60,64-94,1 хувиар, 12 сард 104,2 хувиар биелүүлэн ажиллаа. Сар бүрийн төлөвлөгөө тасарсан шалтгаан нь эхнээс Бор-Өндрийн Монросцветмет Уулын баяжуулах үйлдвэр нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөө төлөхгүй сар бүр 950,0 сая төгрөгийн өр үүсгэснээс орлогын төлөвлөгөө жигд биелэхгүй байсан.

Нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг хамруулах, хуримтлагдсан авлагыг барагдуулах ажлуудыг зохион байгуулсны үр дүнд ажил олгогч **942**, заавал даатгуулагч **14254** болж, оны эхнээс шинээр **78** ажил олгогч, **283** даатгуулагчийг бүртгэн, шимтгэл тооцох цалингийн сан **991,7** сая төгрөгөөр нэмэгдсэн.

Нийгмийн даатгалын сангийн орлого сан тус бүрээр

Сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
Тэтгэврийн даатгалын сан	39285.1	40524.3	103.1
Тэтгэмжийн даатгалын сан	4078.9	4226	103.6
ҮОМШӨ-ний даатгалын сан	3330	3962.5	119
Ажилгүйдэлийн даатгалын сан	836	811.8	97.1
НИЙТ	47530	49524.6	104.2

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төлөвлөгөө **96800,9** сая төгрөгөөс **92147,0** сая төгрөгийн зарлагыг батлагдсан төсөвт багтаан сан тус бүрээр зориулалтын дагуу хэтрүүлэлгүй ажилласан. Нийт зардлын **90,4** хувийг тэтгэврийн даатгалын сан эзэлж байна. 2023 онд давхардсан тоогоор **169** гаруй мянган даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд нь тогтоон бүрэн олгож, тэтгэвэр авагч, даатгуулагч иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг жигд, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэлээ.

Нийгмийн даатгалын сангийн зарлага сан тус бүрээр

Сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	Хэтрэлт - Хэмнэлт+
Тэтгэврийн даатгалын сан	87282.3	83348.4	95.5	3933.9
Тэтгэмжийн даатгалын сан	4356.4	3964.6	91	391.8
ҮОМШӨ-ний даатгалын сан	4096.6	3522.2	86	574.4
Ажилгүйдэлийн даатгалын сан	1065.6	1311.8	123.1	-246.2
НИЙТ	96800.9	92147,0	95.2	4653.9


НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАГДАЛТ

Аймгийн хэмжээнд нийгмийн даатгалын мэдээллийн санд 2023 оны байдлаар нийт **942** төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэн нь эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын **85** хувийг эзэлж байна. Мөн албан журмын болон сайн дурын даатгалд 18,9 мянган даатгуулагч хамрагдсан нь эдийн засгийн идэвхтэй хүн амын **48,5** хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд шинээр **78** ажил олгогч хамруулсан ба албан журмын **283** даатгуулагчийг нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгэн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулан ажиллаа.

Аймгийн хэмжээнд нийт 4328 даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдсанаас шинээр 793 даатгуулагч хамрагдсан. Үүнээс: малчин 2813, шинээр 400 малчин хамрагдсан байна.

Нийгмийн даатгалын хамралт



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН АВЛАГА

2022 оны жилийн эцсээр нийгмийн даатгалын шимтгэлийн авлага нийт **3,877,4** сая төгрөг байснаас жилийн эцсийн байдлаар нийт авлагын **95,8%** буюу **3705.3** сая төгрөгийг барагдуулсан. 2022 оны эцсийн авлагаас **173,1** сая төгрөгийн авлага үлдсэн бөгөөд урсгал авлага жилийн эцсээр **1980,0** сая төгрөг байна. Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогод эзлэх хувь 4 байна

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлсэн:

- Шимтгэлийн авлага барагдуулах гэрээг 6612,1 сая төгрөгийн өртэй 16 байгууллагатай байгуулж 6600.3 сая төгрөгийг барагдуулсан.
- 73 аж ахуйн нэгжийн 541,2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагад дансны хаалт тавьж 382,1 сая төгрөгийн татан авч, нийгмийн

- даатгалын санд төвлөрүүлсэн.
- Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлага үүсгэсэн 31 аж ахуй нэгжийн 113,1 сая төгрөгийн авлагыг Хэнтий аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжилсэн бөгөөд 9 байгууллагын 46,5 сая төгрөгийг шүүхийн шатанд эвлэрч төлүүлсэн. 19 байгууллагын 43,2 төгрөгт шүүхийн шийдвэр гаргуулсан.
 - Мөн оршин суугаа хаяг тодорхойгүй 3 байгууллагын хариуцагчийг эрэн сурвалжлуулах нэхэмжлэл гарган Цагдаагын байгууллагад шилжүүлээд байна.
 - Нийгмийн даатгалын өртэй 74 аж ахуйн нэгж, 25 төсөвт байгууллагын 2810 “Нийгмийн даатгалын тайлан гаргахад анхаарах асуудал, шимтгэл тооцох орлогын бүрэлдэхүүн, байгууллага нь нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй улмаас даатгуулагчийн тэтгэвэр, тэтгэмж хугацаандаа олгогдоогүй хохирлыг хариуцах” талаар сургалт хийсэн.
 - Хуримтлагдсан авлага үүсгэсэн Нийгмийн даатгалын тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэггүй төсөвт байгууллагын мэдээг Санхүү төрийн сангийн хэлтэст, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг гэрээ бүхий байгууллагуудыг Эрүүл мэндийн даатгалын хэлтэст сар бүрийн 15-нд албан бичгээр хүргүүлж, хамтран ажиллаж, өр авлага барагдуулан ажиллаж байна.
 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд 2 аж ахуйн нэгжийн 18.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй. Үүний 11,7 сая төгрөг нь Жижиг эрдэнэ ХХКомпаний өр бөгөөд тухайн өр нь давж заалдах шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж, Нийслэлийн ШШГГ ажиллагаа хийж байх явцад хариуцагч зуурдаар нас барсан. Иргэний хуулийн дагуу өв нээх хугацаа өнгөрсөн ч тухайн нас барагчийн өвийг хүлээж аваагүй байгаа тул ажиллагаа явуулах боломжгүй болсон, Мөн Дорнод Монгол ХХКомпани 6.9 сая төгрөг нь 2000 онд шийдвэр гаргаж 2002 онд ШШГГазарт шилжсэн гүйцэтгэх ажиллагаа хийгдээгүй. Ажиллагааг дахин сэргээхээр Улсын бүртгэлийн хэлтсээс лавлагаа авхад тус компани нь татан буугдсан тул хариуцагчгүй болсон.

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН



Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа **12659** тэтгэвэр авагчид **83300,1** сая төгрөг зарцуулсан байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу шинээр **785** иргэн тэтгэвэр тогтоолгосноос өндөр насны тэтгэвэр 504, тахир дутуугийн тэтгэвэр 214, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 48, цэргийн тэтгэвэр 19 байна. Тэтгэврийг хамтран ажиллах гэрээний дагуу арилжааны банкуудаар сар бүрийн 01-нд олгож хэвшсэн.

Хүснэгт. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Тэтгэврийн төрөл	Суурь түвшин буюу 2022 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2023 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
Өндөр насны	10000	60678,8	10280	68589,1
Тахир дутуугийн	1490	7073,2	1539	8181,8
Тэжээгчээ алдсаны	569	3055,2	573	3259,3
Цэргийн	252	2389,2	267	3269,9
НИЙТ	12311	73196,4	12659	83300,1

Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 238, 239 дүгээр тогтоолын дагуу нэмэгдэл хийснээр дундаж тэтгэвэр **619130** төгрөг, сард олгох тэтгэврийн хэмжээ **8024550,6** мянган төгрөг болж **1289032,2** мянган төгрөгөөр өссөн. Тэтгэврийн нэмэгдлээр 10 хувиас дээш тэтгэвэр нь нэмэгдсэн **4021** тэтгэвэр авагчийн тэтгэвэрийн нэмэгдэлд **863412,18** мянган төгрөг буюу дунджаар нэг тэтгэвэр авагч **214725** төгрөгөөр нэмэгдсэн байна. 10 хувиар тэтгэвэр нэмэгдсэн **8940** тэтгэвэр авагчийн тэтгэвэрт сард **425670,0** мянган төгрөг зарцуулсан байна.

ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН



Тэтгэмжийн даатгалын сангаас **4817** даатгуулагчдад **3045,6** сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгов. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад **211,5** сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт . Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Тэтгэмжийн төрөл	Суурь түвшин буюу 2022 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2023 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан оны хагас жил хөрөнгө
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	3270	934,2	3512	744,4
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	983	1637,2	998	1757,2
Оршуулгын тэтгэмж	317	317,0	307	676,0
НИЙТ	4570	2888,4	4817	3045,6



3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд үлдсэн 50 хувийг даатгуулсан эсэхээс хамаарч тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс олгохоор шийдвэрлэсэн хуулийн хүрээнд 338 эхчүүдтэй гэрээ байгуулж тэтгэмжийн даатгалын сангаас 94,5 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангийн орлогод төвлөрүүлэн ажиллаа.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САН



YOMSHO-ний даатгалын сангаас **988** тэтгэвэр, тэтгэмж авагчдад нийт **3797,6** сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ онд шинээр **34** даатгуулагч тэтгэвэр тогттоолгосон ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад зардал 627,2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Зардлын төрөл	Суурь түвшин буюу 2022 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2023 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
YOMSHO-ний тэтгэвэр	393	2934,2	408	3497,8
YOMSHO-ний тэтгэмж, төлбөр	125	59,7	118	79,4
Тахир дутуу иргэдийн тэтгэврийн даатгалын шимтгэл	340	176,5	462	220,4
НИЙТ	858	3170,4	988	3797,6

АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН



Ажилгүйдлийн даатгалын сангаас **448** даатгуулагчид ажлаас халагдсаны тэтгэмжид **1206,8** сая төгрөг зарцуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 198,5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Зардлын төрөл	Суурь түвшин буюу 2022 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2023 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
Ажилгүйдлийн тэтгэмж	482	1008,3	448	1206,8

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журамд заасан эрх үүргийн хүрээнд хяналт шалгалт хийх, аливаа хууль бус үйлдлийг таслан зогсоох, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэх, дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийн хүрээнд ажиллаа.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Хяналт шалгалт дотоод аудитын тасгийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 13 суманд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх хуваарийн дагуу ажил олгогч даатгуулагчдын цалингийн сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлж байгаа эсэх, нийгмийн даатгалын тухай багц хуулийг хэрхэн хэрэгжүүлж байгаа байдалд Бор-өндөр, Баянхутаг, Цэнхэрмандал, Бэрх, Батноров, Мөрөн, Баян-адрага, Өлзийт, Баянмөнх сумдад төлөвлөгөөт хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар 16 ажил олгогч, байгууллагатай холбоотой 49.5 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлэн гарсан төлбөр зөрчлийн 43.0 хувь буюу 21.3 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулсан байна. Тус хэлтсийн дотоодын хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн 2023 оны эхний үлдэгдэл 39.4 сая төгрөг байсан ба тайлант хугацаанд шинээр 19.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж улсын байцаагчийн актаар баталгаажуулсан. Өмнөх оны үлдэгдэл болон шинээр үүссэн авлагын 31.7 сая төгрөг буюу 53.4 хувийг барагдуулан ажилласан бөгөөд оны эцсийн байдлаар 27.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Өмнөх оны актын үлдэгдэлийн 52.5 хувийг барагдуулан ажилласан. Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авагч даатгуулагчийн материалын үндэслэл, олголтыг тус тус шалгаж 4 даатгуулагчтай холбоотой 2.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж бүрэн барагдуулсан. Мөн өмнөх оны үлдэгдлээс 2.5 сая төгрөгийг барагдуулаад байна.

Малчнаар ажиллаж байсан хугацааг тогтоох “Сумдын засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөл”-ийн тогтоолын 2021, 2022 оны баримтанд хяналт, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар 2021 онд 51 малчин даатгуулагчийн өргөдөл, хүсэлтийн дагуу зөвлөл хуралдаж 47 даатгуулагчийн

материал шийдэгдэн тогтоол гарсан, 4 даатгуулагчийн материал хангалтгүй, бүрдэл дутуу шалтгаанаар буцаагдсан байна. Мөн 2022 онд нийт 24 малчин даатгуулагчийн өргөдөл, хүсэлтийн дагуу зөвлөл хуралдаж 23 даатгуулагчийн өргөдөл шийдвэрлэгдэн тогтоол гарч 1 хүний материалын бүрдэл хангалтгүйн улмаас буцаагдсан байна. 2021, 2022 онуудад тогтоол гарч тэтгэвэр тогтоогдсон 70 малчин даатгуулагчийн зөвлөлийн тогтоолын материалын бүрдэл, баримт бичгийн үндэслэл зэргийг шалгахад ихэнх сумдын архивт хадгалагдаж байгаа малчны А дансны мэдээлэл устсан, үрэгдсэн, шатсан гэсэн тайлбар өгсөн байна. Сумдын ЗДТГ-ын малчны зөвлөл нь тогтоол гаргахдаа ихэвчлэн үрэгдсэн, шатсан малчны А дансны өмнөх болон хойдох жилүүдийн А дансны материал, бусад архивын лавлагаа зэргийг үндэслэн тогтоож байна. 2023 онд нийтдээ 93 малчин тэтгэвэр тогтоолгосноос эрэгтэй 49, эмэгтэй 44 хүн байна. Нийт сумдын байцаагч болон төвийн тэтгэврийн байцаагч нарт иргэд даатгуулагч нарт зөвлөгөө өгөхдөө “Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”-ын дагуу холбогдох материалыг үнэн зөв бүрдүүлэн зөвлөлийн хурлаар оруулж тогтоол шийдвэрийг гаргаж байхыг үүрэг болголоо. Мөн шаардлагатай тохиолдолд шүүхийн шийдвэр гаргуулах зөвлөмж өгсөн.

Архив албан хэрэг хөтлөлтөнд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр баримт бичиг нягтлан шалгах комисс ажиллаж хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ажилтнуудаас тухайн оны санхүүгийн болон бусад баримтыг хүлээн авах хуваарийг тушаал гарган баталж, гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. Сумдын байцаагчдаас байнга хадгалах буюу нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн З-НД7,8 тайлангийн хадгаламжийн нэгжийг нэг бүрчлэн мэдээллийн сантай үлдэгдлийг тулган, тамга, тэмдэг дарагдаж баталгаажсан эсэхэд хяналт тавьж хэлтсийн архивт хүлээлгэн өгсөн. Нийгмийн даатгалын ерөнхий газар болон дээд шатны байгууллагаас ирүүлсэн хууль түүнд нийцүүлэн гаргасан холбогдох эрх зүйн актуудтай тухай бүр танилцан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэнтий аймгийн хэмжээнд нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллогыг хэлтсийн даргын тушаалаар баталгаажуулан тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэргийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтыг тэтгэврийн массив болон нэгдсэн мэдээллийн баазтай тулган шалгахад 22 сумын 13357 хувийн хэрэг бүрэн тоологдсон. Тооллогын явцад тэтгэвэр авагчдын хувийн хэргийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, нэгдсэн мэдээллийн сангийн массивын дарааллын дагуу эмхэлж цэгцлэх, хавтас хаягийг сайжруулах үүрэг өгч ажилласан. Тэтгэвэр авагчидын шилжилт хөдөлгөөнд тухай бүр хяналт тавьж ажиллан зогсоогдсон, нас барсан тэтгэвэр авагчидын хувийн хэргийг жагсаалт үйлдүүлэн улирал бүр сумдаас хэлтсийн архивт хүргүүлж хэвшээд байна. Тэтгэвэр олголтын сар бүрийн файлыг харилцагч банкнаас авч нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэврийн цахим мэдээллийн сантай тулгаж улирал бүрийн сангийн тайлангаар илүү, дутуу олгосон тэтгэвэр дээр хяналт тавьж тооцоо

нийлэн ажилласан. 2023 онд шинээр тогтоогдсон өндөр насны 520 /эрэгтэй 215, эмэгтэй 305/, тэжээгчээ алдсан 54 /эмэгтэй 47, эрэгтэй 7/, тахир дутуугийн 247 /эрэгтэй 157, эмэгтэй 90/ бүгд 821 тэтгэвэр авагчидын хувийн хэргийн баримтийн бүрдэл болон тогтоолт, олголтыг хянан баталгаажуулсан. Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн нэмэгдлээр 12975 тэтгэвэр авагчидад нэмэгдлийг хийж тогтоолтын хуудсыг хэвлэн, баталгаажуулж хувийн хэрэгт хавсаргасан.

ЦАХИМ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб програм”- (<http://10.9.0.5/monitoring>)-д тулгуурлан хяналт, шалгалтыг сар бүр тогтмол хийж байна. Цахим хяналтын программаар шүүгдэж байгаа нийт алдааны 67 хувь нь зөрчлийн шинжгүй алдаа байгаа бөгөөд шийдвэрлэх боломжтой алдааг анхан шатны баримтанд тулгуурлан тухай бүр Санхүү бүртгэлийн тасаг, Үйлчилгээний тасагтай хамтран залруулан ажиллаж байна. Цахим хяналтын программд 2023 онд илэрсэн 1701 алдаа байгаагаас тайлант хугацаанд 316 тэтгэвэр, тэтгэмж, шимтгэл төлөлттэй холбоотой алдааг засаж хаасан байна. Мөн зөрчлийн шинжгүй 212 мэдээллийн тайлбарыг бичиж хаасан. Дээрх илэрсэн зөрчилтэй холбоотой цалин зассан 2 даатгуулагчийн тэтгэвэр тогтоолтонд өөрчлөлт хийж улсын байцаагчийн акт үйлдэн барагдуулсан.

НИЙГЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх нэгдсэн удирдамжийн дагуу Хэнтий аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын нийгмийн халамжийн сангаас давхар тэтгэвэр тогтоолгон авч буй эсэхэд 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 04 дүгээр сарын 10-ний өдрүүдэд шалгалт хийсэн. Шалгалтаар нийгмийн халамжийн сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч байгаад шилжсэн 9 иргэнд илүү олгосон 3.3 сая төгрөгт улсын байцаагчийн акт тогтоосон. Улсын байцаагчийн актад дурьдсан төлбөр зөрчлийг тогтоосон хугацаанд бүрэн барагдуулан ажилласан. Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 03-00/03 тоот удирдамжийн дагуу Хэнтий аймаг дахь Политехникийн коллеж, 07/13 тоот удирдамжийн дагуу Хэнтий аймгийн Бор-өндөр суманд үйл ажиллагаа явуулдаг Монголросцветмет ТӨҮГ-ын харъяа Уулын баяжуулах үйлдвэр, Дархан сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг Баянтэгш ХХК, Лутчулуу ХХК, Арвижих хүдэр ХХК зэрэг боловсролын болон уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг 6 ажил олгогчийн 2022, 2023 оны баримтанд нийгмийн хамгааллын шалгалтыг ХХҮГ-ын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчтай хамтран хийж гүйцэтгэсэн.

ЗӨРЧИЛЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР

Зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулах, хяналт тавих, эрх бүхий албан тушаалтны судалгаа, тайлан мэдээг цаг хугацаанд нь гарган Нийгмийн даатгалын ерөнхий газар болон холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу 5 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой гомдол мэдээллийг хүлээн авч материалыг хянан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар шийдвэрлэж буруутай 5 байгууллагыг тус бүр 250 нэгжээр торгон нийт 1250.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсаныг барагдуулан ажилласан. Дээрхи 5 байгууллагатай холбоотой гомдол мэдээллийн дагуу Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар зөрчил хянан шийдвэрлэх материал бүрдүүлэн Хэнтий аймгийн прокурорын газраар хянуулан 23636.4 мянган төгрөгийн акт, алданги ногдуулсаныг бүрэн барагдуулсан.

ДОТООДЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Хяналт, шалгалтын тайланг улирал бүр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэлийн тайлантай тулган баталгаажуулж, НДЕГ-ын ХШГазарт хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Дотоодын хяналт, шалгалтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд хяналт, шалгалт дотоод аудитын тасаг нь сумдын байцаагч нарт долоо долоо хоногоор шинээр нийгмийн даатгалын шимтгэлийн урсгал авлага үүсгэж байгаа аж ахуй нэгж байгууллагатай уулзалт хийх, албан шаардлага хүргүүлэх, данс хаах, шүүх хяналтын байгууллагад хүргүүлэх зэрэг хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хүснэгтээр авч хяналт тавьж ажилласан. Мөн нийгмийн даатгалын сангийн сар улирлын тайлангаар гарч байгаа бусад авлага буюу 1218 тоот дансанд бүртгэгдсэн илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тухайн сар улиралд багтаан шуурхай барагдуулан нийгмийн даатгалын санг хохиролгүй болгох ажлыг тухай зохион байгуулан ажилласан. Хэлтсийн дотоодын хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн 2023 оны эхний үлдэгдэл 39.4 сая төгрөг байсан ба тайлант хугацаанд шинээр 19.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж улсын байцаагчийн актаар баталгаажуулсан. Өмнөх оны үлдэгдэл болон шинээр үүссэн авлагын 31.7 сая төгрөг буюу 53.4 хувийг барагдуулан ажилласан бөгөөд оны эцсийн байдлаар 27.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Өмнөх оны актын үлдэгдэлийн 52.5 хувийг барагдуулан ажилласан.

ГОМДЛЫН ШААРДЛАГЫН ЗӨВЛӨЛ

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Гомдолын шаардлагын салбар зөвлөлд 2023 онд 5 өргөдөл, гомдол ирсэн. Тус зөвлөлд ирсэн өргөдлийн дагуу 7 удаа хуралдаж 3 даатгуулагчийн өргөдөлд хавсаргасан

материал, ажилсан байдал, холбогдох бусад материалыг үндэслэн нөхцөл хангасан гэсэн шийвэр гаргасан. Бусад 2 даатгуулагчийн өргөдөл, бүрдүүлсэн материалын ажилласан жил, хавсаргасан материалыг хангалтгүй гэж үзэн буцаасан байна.

“МАЛЧНААР АЖИЛЛАЖ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛСӨН ХУГАЦААГ ТОДОРХОЙЛОХ ЗӨВЛӨЛ”

Тайлант хугацаанд 9 сумын **“Малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл”** 12 удаа хуралдаж 13 иргэний асуудал хэлэлцэж 13 малчинд зөвлөлийн тогтоол гаргасан байна. Зөвлөлийн тогтоол гаргасан иргэдээс 5 нь малчин тэтгэвэр тогтоолгосон байна

ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Эмнэлэг Хөдөлмөр Магадлах Комисс нь энэ онд нийт 46 удаагийн хурлаар 2261 иргэний асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Үүнд шинээр 302, цуцалсан 168, буцаасан 25, сунгагдсан 1960, хугацаагүй дахин магадласан 85, шилжиж явсан 22, шилжиж ирсэн 10 иргэнд үйлчилсэн. Нүүдлийн хурлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд болон ар гэрийн асран хамгаалагч нарт мэргэжлийн эмч нар, халамжийн байцаагч, нийгмийн даатгалын чиглэлээр тус тус сургалтыг 4 удаа хийсэн. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагуудтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаар 4 удаагийн сургалт мэдээллийг зохион байгуулж ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоох сунгах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх асуудлыг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй хуулийн хүрээнд, үнэн зөв шийдвэрлэж байна.

2023 оны тайлант хугацаанд Эмнэлэг хөдөлмөр магадлалын цахим мэдээллийн сангийн бүрдэлд хөдөлмөр, халамжийн үйлчилгээний мэргэжилтэн, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр мэдээллийн цахим санг хувийн хэрэгтэй тулган шалгах хяналт, шалгалтыг ажлыг 2 удаа хийсэн. Шалгалтаар:

- 2023 оны жилийн эцсийн тоон мэдээллээс нас барсан 8, шилжсэн 3, Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 5, цуцлагдсан 5 нийт 21 иргэний мэдээлэлийг цахим санд хөдөлгөөн хийлгүй орхисон зөрчлийг илрүүлэн мэдээллийн баазад залруулан, хөдөлгөөнийг оруулан зөрчлийг арилгасан.
- Улсын бүртгэлийн мэдээллийн бааз ЭХМК-ын программд 2 даатгуулагчийн овог, нэр зөрсөн байсныг тулган шалгаж ЭХМК-ын мэдээллийн программд зөрчлийг арилган засварласан. Мөн нас барсан 1 иргэний мэдээллийг Улсын бүртгэлийн хэлтсээс тодруулан шалгуулж зөрчлийг арилгаж ажилласан.
- Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран хаягийн бүртгэлийн мэдээлэлийг шалган шалган үзэхэд:

Улаанбаатарын харъяат – 15, Налайх дүүргийн -1, Багахангай дүүргийн -1, Дорноговь аймгийн -1, Дорнод аймгийн -1 иргэн байсныг илрүүлэн ЭХМК-ын мэдээллийн баазад шилжих хөдөлгөөн оруулан зөрчлийг арилгасан.

Хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдийг Эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах эмчилгээний талаар : Сумдын эмч нар хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ тавих хяналтаа сайжруулж, эмчлэн эдгэрүүлэх төлөвлөгөө боловсруулж, ЭХМК-ын хурлаар эмчлэгч эмч өөрийн биеэр иргэдээ авчирч танилцуулж байна. Сэргээн засах тасгийн эрхлэгч Хатанбаатар эмчтэй хамтран ажиллаж физик эмчилгээнд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нэмэгдүүлэн, эмчилгээнд бариа заслаас гадна зүү төөнүүр, хөдөлгөөн засал, татлага зэрэг эмчилгээний төрлийг нэмсэн нь үр дүнгээ өгч байгаа бөгөөд одоогийн байдлаар 32 иргэн хэвтэн эмчлүүлээд байна.

Хурлын байрны асуудлын талаар:


Хурлын байрны асуудлыг Аймгийн засаг дарга болон Нэгдсэн эмнэлэгийн удирдлагад удаа дараа танилцуулсан боловч бүрэн шийдэгдээгүй. Одоогоор байрны хүрэлцээ муутай гэсэн шалтгаанаар түр өрөөнд хурал явагдаж байна. Хурлын өрөөний асуудлаас болоод иргэд хуралд 3 дахь, 4 дэх өдрийг дамжин 2 хоног зарцуулдаг байсныг нэгдсэн эмнэлгийн удирдлагуудтай хэлэлцэж 1 дүгээр хурлыг 3 дахь өдрийн 10-13 цаг, 2 дугаар хурлыг 12 цагаас эхлэн хуралдаж хэвшээд байна. Мөн өвлийн улирал цаг агаарын бэрхшээлийг үнэлэн дотооддоо хуралдаж ЭХМК-ын шийдвэрийг тухайн эмнэлэг дээрээ хэлэлцэн картыг 2-р хуралд илгээх мөн хурлыг цахимаар болон бичиг баримтанд тулгуурлан хийж эхэлсэн.

Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолын хавсралт “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм” , Ерөнхий газрын даргын А/38 тоот тушаалын хавсралт “Эмнэлгийн хуудас олгох, хянах журам” -аар эмнэлэг хяналтын болон өрхийн эмнэлгүүд, Дархан, Баянмөнх, Галшар, Бор-өндөр сумдад 2023 оны 05 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд, 6 дугаар сард Норовлин, Дадал, Баян-адрага, Биндэр, Батширээт, 8 дугаар сард Дэлгэрхаан, Жаргалтхаан, ХБУлаан, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумдын эмч, мэргэжилтнүүдэд сургалтыг зохион байгуулсан. Мөн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр УИХ-аар батлагдсан Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Ерөнхий газрын даргын А/38 тоот тушаал “Эмнэлгийн хуудас олгох, хянах журам”-ын талаарх сургалтыг нийгмийн даатгалын хэлтсээс зохион байгуулсан. Сургалтанд ЭМГазрын ажилтан, албан хаагчид болон нэгдсэн эмнэлгийн эмч, ажилчид оролцсон ба дээрх хууль журмуудтай холбоотой заавар, зөвлөгөөг өгсөн.

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын чанар хүртээмж, хамралтыг сайжруулах зорилгоор ажил олгогч, даатгуулагч болон ажилтнуудыг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулахад анхаарч ажиллаа. Тухайлбал:

➤ Мэргэшүүлэх сургалтыг дотооддоо Нийгмийн даатгалын ерөнхий газар болон хэлтэс, орон нутгийн байгууллагаас зохион байгуулсан албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх **47** удаагийн цахим болон танхимын сургалтанд давхардсан тоогоор **1024** албан хаагчдыг хамруулсан.



➤ Ажил олгогч даатгуулагчдад чигэлсэн сургалтыг оны эхнээс төлөвлөгөө гарган хэлтсийн даргаар батлуулан ажилласнаар нийтдээ **225** аж ахуйн нэгж байгууллага, **88** баг, **788** ЕБС-ийн ахлах ангийн сургачдад, **288** сургалт зохион байгуулж **17522** даатгуулагч хамруулсан.

ААН албан байгууллага, иргэд даатгуулагчид чиглэсэн сургалтын хүрээнд **225** сургалт, уулзалт хийсэн. **11304** иргэд, даатгуулагчид сургалт, уулзалтад хамрагдаад байна.





Хэнтий аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдсан **"Манлайлагч ахмад"** чуулга уулзалт, **"Залуу малчид"**-ын чуулга уулзалтад Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, сэдвээр ХНХЯ-ны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилийг зохицуулах газрын дарга Б.Батжаргалыг урьж оролцуулан мэдээлэл сургалт хийлээ.



НДЕГ-ын СБГ-ын дарга Б.Даваахүү Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулдаг 150 гаруй ажил олгогч байгууллагын 300 даатгуулагчдад Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн талаар танилцуулж, иргэдийн асуултад хариулт өглөө.



Өдөрлөг 5, Явуулын үйлчилгээ 28 цэгт зохион байгуулж нийт 3483 иргэд даатгуулагч хамруулсан.





Ахлах ангийн сурагчид болон политехник коллежийн Оюутан сурагчдад зориулсан “Ирээдэйтэй даатгал” нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах 25 сургалтыг зохион байгуулж 788 сурагчийг хамруулсан.



- Хэнтий мэдээ сонины фэйж хуудас, сайтаар, www.ndaatgal.khe.gov.mn вэб сайт, www.facebook.com/NDKHenti фэйсбүүкээр, “Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс” фэйж хуудсаар **87** мэдээлэл, постер оруулж мөн ХНХЯам, НДЕГазраас бэлтгэсэн **55** төрлийн сурталчилгаа, мэдээ, мэдээллийг цахим сүлжээ ашиглан олон нийтэд хүргэсэн ба давхардсан тоогоор **250** мянга гаруй иргэд даатгуулагчдад хүрсэн байна.





ТАЙЛАН БИЧСЭН :
ХЭЛТСИЙН ДАРГА

/Н. НЯМХАТАН/